

БАТЛАВ:

БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ,
АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.ХАНДСҮРЭН

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

НБИК ХХК-НЫ БАРИЛГА ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Б.БАТ-ОРШИХ

“ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ”-ИЙН ХӨВСГӨЛ

АЙМГИЙН АЛАГ-ЭРДЭНЭ СУМАНД ХЭРЭГЖИХ

“А1: ХӨВСГӨЛИЙН УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГАА БА
ЖУУЛЧНЫ МЭДЭЭЛЛИЙН ТӨВИЙН БАРИЛГА УГСРАЛТ”-Н АЖЛЫН

2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРЫН ДУГААР: 5403502/

ХЯНАСАН:

ХБОХБГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН:

П.НЯМСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:

НБИК ХХК-НЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ ИНЖЕНЕР:

Э.ГАНХУЯГ

2025 ОН

Удиртгал

Азийн хөгжлийн банкны санхүүжилттай Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны захиалгаар хийгдэж буй “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл” нь Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газар, (ХУТХГ) болон Онон-Балжийн байгалийн цогцолборт газар (ОББЦГ)-т үндэсний жишиг зорин очих газрыг бий болгохыг зорьж байна. Энэ хүрээнд тогтвортой, хүртээмжтэй эко аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгаль хамгаалал, аялал жуулчлал, эдийн засгийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхээр Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны нутаг дэвсгэрт Хөвсгөлийн тусгай хамгаалалттай газарт “Хамгаалалтын захиргаа, жуулчны мэдээллийн төв” -ийг байгуулснаар доорх боломжууд нээгдэх юм.

- ✓ Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх;
- ✓ Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг бодитоор дэмжих;
- ✓ Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн онцгой архитектурын хэв маягийг шингээсэн Жуулчдын мэдээллийн төв бүтээн байгуулах;
- ✓ ТХГН-ын үйл ажиллагааг сайжруулан өргөжүүлэх;
- ✓ Санхүүгийн менежмент сайжрах;



Зураг 1. Төслийн хэрэгжих талбайн байр зүйн зураг

“Хамгаалалтын захиргаа, жуулчны мэдээллийн төв” -ийн нэг давхар барилга болон авто зогсоол, ногоон байгууламж, гадаа талбайн гэрэлтүүлэг, сандал, жуулчдад зориулсан мэдээллийн самбар бүхий орчны тохижилтын ажлыг хийж гүйцэтгэхээр “НБИК” ХХК ажиллаж байна. Манай компани барилга угсралт, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл

ажиллагаа явуулахаар 2010 онд анх үүсгэн байгуулагдаж, одоо 160 гаруй инженер техникийн ажилтан, 800 гаруй мэргэжлийн ажилчдын бүрэлдэхүүнтэйгээр барилга угсралт, гадна инженерийн шугам сүлжээ, дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмжийн угсралт, мөн барилгын цахилгаан хангамж, дотор гадна гэрэлтүүлгийн системийн угсралт, бетон зуурмагийн үйлдвэрлэл, лаборатори, геодезийн тандалт судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Одоогоор “Хамгаалалтын захиргаа, жуулчны мэдээллийн төв”-ийн барилгын суурийн ажил, худаг гаргах болон гадна цахилгаан татах ажлууд хийгдсэн байна.



Зураг 2. Хамгаалалтын захиргаа, жуулчны мэдээллийн төв

Цаашид төслийн барилга, байгууламж барих үеийн байгаль орчныг хамгаалах бүхий л үйл ажиллагаандаа чухал ач холбогдол өгч тогтмол үзлэг хийн хяналт тавьж, холбогдох Монгол улсын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм журам, стандарт норм, аргачлалын шаардлагуудыг биелүүлж, байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах зарчим баримтлан ажиллана. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэхдээ Монгол улс болон олон улсын хууль эрхзүй, Азийн хөгжлийн банкны баримтлах зарчим, шаардлагын хүрээнд төр захиргааны байгууллага, захиалагч тал болон орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллана.

“НБИК” ХХК-ны зүгээс төслийн талбайд ажиллах инженер техникийн ажилчид нь орон нутгийн ойролцоох жуулчны баазад байрлан ажиллахаар төлөвлөсөн бөгөөд 2025 онд хийгдэх барилга байгууламжийн ажлын гүйцэтгэх хугацааг дараах байдлаар төлөвлөөд байна.

Хүснэгт 1. 2025 онд барилга байгууламж барьж гүйцэтгэх урьдчилсан төлөвлөгөө

№	Барилга, байгууламж	Төлөвлөгөөт хугацаа	
		Эхлэх	Хүлээлгэн өгөх
1	Ариун цэврийн байгууламжийн барилга - Соёлын төв	9-Jun-25	6-Sep-25
2	Хатгал тосгонд авто замын төлбөр авах цэгийн барилга	8-May-25	4-Aug-25
3	Ариун цэврийн байгууламжийн барилга - Чөчү	5-Jun-25	26-Jul-25
4	Ариун цэврийн байгууламжийн барилга - Жанхайн даваа	1-May-25	29-Jul-25
5	Мөрөн суманд барих ариун цэврийн байгууламжийн барилга	20-May-25	4-Sep-25
6	Ариун цэврийн байгууламжийн барилга - Наадмын талбай	3-Jun-25	10-Sep-25
7	ХУТХГ-ын хамгаалалтын захиргаа, жуулчны мэдээллийн төвийн барилга	1-Apr-25	13-Nov-25

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт “*Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам*”-ын аялал жуулчлал, үйлчилгээний төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах агуулгыг баримтлан, 2022 онд байгаль орчны төрийн захиргааны төв байгууллагаар батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, түүнд тусгагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөрдлөг болгов.

1. Байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд тусгаснаар төслийн үйл ажиллагаанаас амьтны аймаг, усны нөөц, чанарт үзүүлэх шууд нөлөөлөл байхгүй гэж үзсэн байна. Тус төслийн талбай орчимд одоогоор түүх, соёлын өв илрээгүй, үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “*Соёлын өвийг хамгаалах тухай хууль*” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллана.

“Хамгаалалтын захиргаа, жуулчны мэдээллийн төв” төсөл нь нийт 17263.15 м² талбайд үйл ажиллагаа явуулах ба барилгажих хэсэг буюу 815.55 м² талбайн шимт хөрс, хөрс хуулалтад, нийт талбайн 80 хувь нь тодорхой хэмжээгээр барилга байгууламжийн нөлөөлөлд өртөж байгалийн унаган төрх алдагдах, ялангуяа газрын хөрс эвдрэх, түүний хамт ургамлан нөмрөг устгах гол сөрөг нөлөөлөл байна.

Төслийн барилгын ажлын төлөвлөгөөний дагуу хийгдэх нэг чухал анхаарах ажил нь төлбөр авах цэгийн /ТАЦ/ авто замын ажил бөгөөд энэхүү ажлыг 2025 оны 5 дугаар сарын 3 -аас 8 дугаар сарын 4 -ны хооронд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн ба үүнд одоо байгаа 1.2 км шороон замыг /Зураг 3/ сэргээж түр ашиглах, тэмдэг тэмдэглэгээжүүлэх, тоосжилт үүсэхээс сэргийлэн усалгаа хийж байх шаардлагатай юм.

ТӨЛБӨР АВАХ ЦЭГИЙН БАРИЛГЫН АЖЛЫН ҮЕД АШИГЛАХ ТҮР ЗАМЫН ТӨЛӨВЛӨЛТ



Зураг 3. ТАЦ-зам, барилгын ажлын үеийн түр замын зураг

Үүнд шаардлагатай тэмдэг тэмдэглэгээ хийх ажлууд нь барилгын ажлын дотоод санхүүжилтээр хийгдэж харин усалгаа хийх нормыг БОНХАЖ-н сайдын А/301 норм батлах тухай тушаалд заасан нормоор зарцуулагдах усны хэмжээг тооцон зардлыг БОННУ- ийн нэмэлт санхүүжилтээр хийхээр байна /Хүснэгт 2/.

Нийт замын ажилд түгээмэл тархацтай ашигт малтмал буюу 154.9 м³ хайрга шаардлагатай ба үүнийг Жанхайн давааны замын ажил гүйцэтгэж буй “Таван огторгуй” ХХК-иас худаадан авах гэрээгээр авахаар төлөвлөөд байна.

Төслийн барилга байгууламж барих, зам тавих, бүтээн байгуулалтын ажлын үе шатанд доорх сөрөг нөлөөллүүд үүсч болзошгүй ба бууруулах арга хэмжээг доорх хүснэгтээр үзүүллээ.

Хүснэгт 2. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөлөл үүсгэх эх үүсвэр	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал, төгрөг	Хугацаа /сар/
1	Агаарын бохирдол, тоосжилт	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн	Зогсоол байгуулах /Шон суулгах/	Ширхэг	₮ 63,800	20	₮ 1,276,000	IV
			Замын тэмдэг тэмдэглэгээ байрлуулах	Дотоод санхүүжилт				IV
			Тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлах					IV-X
			Төлбөр авах цэгийн замын ажлын үед хэрэглэх түр замын усалгаа хийх	өдөр	25000	60	₮ 1,500,000	VI
		Тээврийн хэрэгслийн дотоод шаталтын хөдөлгүүр, тоног төхөөрөмжийн ажиллагаа	Агаар бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх хэмжээнд хяналт тавих	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр				IV-X
			Төслийн талбайд тээврийн хэрэгслийн холбогдох, стандарт, норм, дүрэм, журмыг мөрдөх					IV-X
2	Үнэрийн бохирдол	Ил задгай хог хаягдал хаях, шингэн хаягдал асгах, бие засах	Нийт ажилчдад урьдчилан зааварчилгаа өгч сэргийлэх, хяналт тавих					IV-X
			Хогийг ангилан ялгаж, зориулалтын хогийн саванд хаях					IV-X
			Бохир ус хуримтлуулах ёмкость байрлуулах	Дотоод санхүүжилт				VI
			Хог хаягдлын их хэмжээний хуримтлал үүсгэхгүйгээр зайлуулж байх	Хог хаягдлын менежмент				IV-X
			Био 00 -д ариутгал үйлчилгээг тогтмол хийх	Дотоод санхүүжилт				IV-X
3	Гүний болон гадаргын ус бохирдох	Гүний худаг	Худгийн тоолуур тавих, ус ашиглалтын гэрээ хийх	Дотоод санхүүжилт				IV
		Ил задгай хог хаягдал хаях, шингэн хаягдал асгах, бие засах	Нийт ажилчдад урьдчилан зааварчилгаа өгч сэргийлэх, хяналт тавих					IV-X
			Хогийн сав, бохир ус хуримтлуулах савны бүрэн бүтэн байдалд хяналт тавих					IV-X
			Био 00-н бүрэн бүтэн байдалд хяналт тавих					IV-X
		Үер, гадаргын усны урсац	Төслийн талбайг үерийн болон гадаргын усны урсацаас хамгаалсан далан, суваг, шуудуутай болгох, эвдэрсэн үед сэргээж байх	Дотоод санхүүжилт				IV-X
		4	Хөрс бохирдох	Ил задгай хатуу, шингэн хог хаях	Нийт ажилчдад урьдчилан зааварчилгаа өгч сэргийлэх, хяналт тавих			
Хогийн сав, бохир ус хуримтлуулах сав, био 00-н бүрэн бүтэн байдалд хяналт тавих								
Барилгын хог хаягдлыг тухай бүрт нь зайлуулж байх	Хог хаягдлын менежмент				IV-X			
Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлээс үүсэх асгаралт	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ажиллах цаг, хүчин чадалд хяналт тавих							IV-X
	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангуулах							IV-X
	Асгаралтын иж бүрдэл, засвар үйлчилгээний үеийн тос шингээгчтэй зориулалтын дэвсгэр хэрэглэх			Дотоод санхүүжилт				V-IX
5	Ургамлан нөмрөг устгах	Тээврийн хэрэгсэл, явган хүн зорчих	Төв замаас төслийн талбай хүртэл нэг замтай байх					IV-X
			Замын таних тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах	Дотоод санхүүжилт				IV-X
			Төслийн объектууд хооронд явган хүний зам тавих	ширхэг	₮ 3,400	1500	₮ 5,100,000	IV-X
			Зам тавих, засварлах /хүн хүчний зардал/	хүн	₮ 500,000	4	₮ 2,000,000	IV-X
НИЙТ				₮ 9,876,000				

- Барилгын ажлын төсөвт багтсан/дотоод санхүүжилт
- БОННУ-ийн нэмэлт зардал


Сөрөг нөлөөллийг бууруулахад удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах нь чухал бөгөөд зарим төсөвт ажлын зардал ХАБЭА -тай холбоотой дотоод санхүүжилтаар хийгдэнэ.

2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

“Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, хамрах хүрээ” MNS 6426:2013 стандартын 5.1.8. Эдэлбэр газрын нийт талбайн 20-с багагүй хувьд ногоон байгууламжтай хөл газрын ургамалгүй байна гэсэн шаардлагын дагуу нийт төслийн 17263.15 м² талбайн 3452.63 м² -д биологийн нөхөн сэргээлт, ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт тохижилтын ажил хийгдэнэ.

Ногоон байгууламж хийж гүйцэтгэхдээ доорх стандартуудыг мөрдлөг болгохоос гадна холбогдох норм нормативыг баримтлан олон наст ургамлын үр, модны суулгацуудын тооцооллыг гаргасан болно.

- ✓ “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага” MNS 5918:2023
- ✓ “Шилмүүст төрлийн модны суулгац. Техникийн шаардлага” MNS 6139:2010
- ✓ “Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах” MNS 6260:2011
- ✓ “Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээ” MNS 5973:2009



Зураг 4. Орчны тохижилтын төлөвлөлт

Хүснэгт 3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлт хийх арга хэмжээний зардал

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төгрөг	Тоо хэмжээ	Нийт зардал, төгрөг	Хугацаа /сар/
1	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлт	Модны суулгац суулгах	Ширхэг	₮ 40,000	490	₮ 19,600,000	IX
		Цэцгийн мандал тарих /суулгацаар/	м ²	₮ 100,000	10	₮ 1,000,000	V-IX
		Зүлэгжүүлэлт хийх /олон наст зүлгийн үрээр/	кг	₮ 25,300	5	₮ 126,500	V-VI
		Хар шороо	тн	₮ 200,000	2	₮ 400,000	V
		Элс	тн	₮ 80,000	2	₮ 160,000	V
2	Арчилгаа тордлогооны зардал	Услалтын систем				₮ 800,000	V
3	Төлбөр авах цэгийн замын өргөтгөлд орсон ногоон байгууламж шилжүүлэх	Суулгац шилжүүлэх	Ширхэг		62	₮ 600,000	V
		Хашаа шилжүүлэх ажил	м		174		
НИЙТ			₮ 22,686,500				


☐ - БОННУ-ийн нэмэлт зардал



Зураг 5. Шилжүүлэх шаардлагатай ногоон байгууламж

3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Төслийн барилга байгууламж барих ажлын явцад ахуйн болон барилгын хог хаягдал гарах бөгөөд “Хог хаягдлын тухай хууль” -ийн хүрээнд “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булилах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”-ын дагуу зохицуулах ба “Барилга доторх хог хаягдлын менежмент-Ашиглалтын дүрэм” MNS BS 5906:2018 стандартыг мөрдлөг болгон төслийн талбайд ахуйн хог хаягдлыг ангилан ялгалт хийж хаях зориулалтын хогийн цэгүүдийг байршуулан, дахин боловсруулах хог хаягдлыг цуглуулах, бусад барилгын хаягдлыг хог хаягдал тээвэрлэх зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан зайлуулж байхаар төлөвлөж байна. Мөн барилга байгууламж барих бүхий л үе шатанд хог хаягдал үүсгэх эх үүсвэрийг хязгаарлах, бууруулах шаардлага тавьж ажиллахаас гадна өнөө үед дэлхийн чиг хандлагын дагуу 4R зарчмыг баримталж ажиллана.



Хүснэгт 4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардал

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төгрөг	Тоо хэмжээ	Нийт зардал, төгрөг	Хугацаа /сар/
1	Ахуйн	9 тонны 3 ангилал бүхий нэгдсэн бункер	Ширхэг	₮ 3,000,000	1	₮ 3,000,000	IX
2	Барилгын	Барилгын материалын хог хаягдал зайлуулах	Удаа	₮ 150,000	28	₮ 4,200,000	Тухай бүрт нь
НИЙТ			₮ 7,200,000				

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд тусгасны дагуу мэдээллийн төвөөр өдөрт 1400 аялагч үйлчлүүлэх бөгөөд хатуу хог хаягдлын тооцоог өдөрт 1 хүн 0.3 кг байхаар тооцвол сард 12600 кг хог хаягдал гарна. Иймд хатуу хог хаягдлыг түр хадгалах нэгдсэн бункерийг нийт 9 тонны багтаамж, 3 секц бүхий ус чийг нэвтэрдэггүй, ангилан ялгах, ачилт хийх боломжтой байдлаар сонгох нь зүйтэй тул доорх байдлаар төлөвлөж байна.



Зураг 6. Нэгдсэн хог хаягдлын бункер

4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хөтөлбөр нь энэ төслөөс байгаль орчин, хүний эрүүл мэндэд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хянах цаашлаад бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлох үндэслэл болж өгдөг учраас байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд мониторинг хийж дата бүрдүүлэх шаардлагыг үндэслэн итгэмжлэгдсэн лабораториудаар 7 үзүүлэлтээр шинжилгээ хийлгэхээр төлөвлөсөн.

Үүнд доорх стандартуудыг мөрдлөг болгон шинжилгээ судалгаа хийнэ.

- ✓ “Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага” MNS 4943:2011
- ✓ “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 5850:2019
- ✓ “Агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх агууламж болон физикийн сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 4585:2016
- ✓ “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018

Хүснэгт 5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Нэгжийн зардал, төгрөг	Тоо хэмжээ	Нийт зардал, төгрөг	2025 он /сар/	2026 он /сар/
1	Хөрсний агрохимийн шинжилгээ	Төслийн талбайн ашиглалтгүй хэсэг	₮ 68,500	3	₮ 205,500	IV, IX	III
2	Орчны хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бактерийн тоо	Хог хаягдлын цэг орчим	₮ 26,400	3	₮ 79,200	IV, IX	III
3	Хөрсний хүнд металлын шинжилгээ	Авто зогсоолын ойролцоо, барилгын талбай	₮ 22,000	3	₮ 66,000	IV, IX	III
4	Ca, Mg, Cl, SO ₄ , NO ₃ , NO ₂ , NH ₄ , HCO ₃ , Fe, As, Na, K, Cd, Cu, Pb, Zn, Cr, Ni, Ag, Al, B, Ba, Mg, Mn, Se, Sr, Mo, Co, Be, Sb, Ca, Cr6 ийн агууламж, амт, үнэр, өнгө, pH, нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулаг, цахилгаан дамжуулах чанар, усны түвшин	Гүний худгаас	₮ 78,000	3	₮ 234,000	VI, IX	III
5	Ундны усны микробиологийн бүрэн шинжилгээ		₮ 48,000	3	₮ 144,000	IV, IX	III
6	Ундны усан дахь хүнд металлын агууламж		₮ 25,000	3	₮ 75,000	IV, IX	III
7	Агаарын чанарын үзүүлэлт SO ₂ , CO, NO ₂ болон Тоосны хэмжилт: PM ₁₀ , PM _{2.5} Тоосны чөлөөт уналт Тоосны найрлага, бүтэц Тоосны тархал	Төслийн талбайн барилга баригдах хэсэгт, авто зогсоолын хэсэгт	₮ 70,000	5	₮ 350,000	IV, VI, VII, IX	III
НИЙТ			₮ 1,153,700				

☐ - БОННУ-ийн нэмэлт зардал

5. БОМТөлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч талууд, оршин суугчдад тайлагнах

Төслийн 2025 оны байгаль орчны менежментийн биелэлтийн тайланг Хөвсгөл аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-т 11 дүгээр сарын 01-ны дотор, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд 12 дугаар сарын 1-ний дотор хүргүүлнэ. Мөн төслийн явц, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулах уулзалтыг Алаг-Эрдэнэ сумын ИТХ-ын гишүүд, ажлын хэсэг, орон нутгийн иргэдтэй тус бүр хоёр удаа, Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл, захиалагч талтай сар бүр зохион байгуулахаар төлөвлөсөн.

Хүснэгт 6. БОМТөлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах хуваарь

№	Уулзалтын хамрах хүрээ	Төслийн явц, төлөвлөгөөний хэрэгжилтийг мэдээлэх хэлбэр	Байршил	Хугацаа /сар/	Зардал, төгрөг
1	Алаг-Эрдэнэ сумын ИТХ	Уулзалт, бичгээр, илтгэл	ЗДТГ	VI, X	
2	Орон нутгийн оршин суугчид	Уулзалт, илтгэл, нийгмийн сүлжээ, видео	Орон нутагт	V, X	
3	Захиалагч тал, Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл	Уулзалт, бичгээр	Төслийн талбай	II, IV, V, VI, VII, VIII, IX, X, XI	
4	Орон нутгийн хяналт тавих ажлын хэсэг	Уулзалт, бичгээр	Төслийн талбай	VI, X	
НИЙТ					₮ 23,000,000

□ - БОННУ-ийн нэмэлт зардал

6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний удирдлага зохион байгуулалт

2025 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэрээ хийх, дүгнэлт гаргуулах, байгаль орчны аудит хийлгэх зэрэг бусад талуудтай хамтран ажиллах, сургалт явуулах, тайлан гаргах мөн урьдчилан таамаглаагүй үйл ажиллагааны зардал, үнийн өсөлт, байгаль орчны болзошгүй эрсдэл, оролцогч талууд бусад этгээдийн санал, зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой хамтран ажиллах, бусад ажлуудад нийт 22 000 000 төгрөгийг зарцуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 7. БОМТөлөвлөгөөний хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын зардал

№	Удирдлага зохион байгуулалтын зардал	БОННУ-н дагуу дотоод санхүүжилт	БОННУ-ийн нэмэлт зардал	Нийт зардал, төгрөг
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	₮ 5,000,000	₮ 17,000,000	₮ 22,000,000

Дүгнэлт

Төслийн хүрээнд Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газарт “Хамгаалалтын захиргаа, Жуулчны мэдээллийн төв” байгуулах ажлын үеийн байгаль орчны сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 2025 онд нийт 49 нэгж арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд эдгээр ажлуудыг гүйцэтгэхэд нийт 85 916 200 төгрөгийг зарцуулахаар /үүнээс 42 662 500 төгрөгийг БОННУ-нд тусгагдсаны дагуу НБИК ХХК өөрийн төсөвөөс санхүүжүүлэх/ байна.

Цаашид байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрхзүй баримт бичиг, стандарт, журам, дүрэм, Азийн хөгжлийн банкны хамгааллын бодлогын хүрээнд сургалт явуулах, оролцогч талууд, орон нутгийн иргэдийн санал хүсэлтийг тусгахад анхаарч ажиллах юм. Мөн хэрэгжүүлэлтийг

барилгын ажлын үйл явцтай уялдуулан, төлөвлөсөн цаг хугацаанд гүйцэтгэхэд чухал ач холбогдол өгч байна.

Хүснэгт 8. 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын зардал

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	БОННУ-н дагуу дотоод санхүүжилт	БОННУ-ийн нэмэлт зардал	БОМТөлөвлөгөө хэрэгжүүлэх нийт зардал
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	₮ 8,376,000	₮ 1,500,000	₮ 9,876,000
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	₮ 22,086,500	₮ 600,000	₮ 22,686,500
3	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	₮ 7,200,000	-	₮ 7,200,000
4	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	-	₮ 1,153,700	₮ 1,153,700
5	БОМТөлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч талууд, оршин суугчдад тайлагнах	-	₮ 23,000,000	₮ 23,000,000
6	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	₮ 5,000,000	₮ 17,000,000	₮ 22,000,000
НИЙТ		₮ 42,662,500	₮ 43,253,700	₮ 85,916,200